

**Аймгийн Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөр
Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар
2024 оны хагас жил**

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Суурь түвшин	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
2. ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ								
1	2.1.1. Нотолгоонд суурилсан оношлогоо эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, иргэдэд орон нутагтаа нарийн мэргэжлийн оношлогоо, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.	1. Анхан шатны 24 нэгжийн эрүүл мэндийн төвийн лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх	2021 - 2024	60	0	100	Эрүүл мэндийн төв нь 2022 онд шээсний анализатор, биохимийн хагас автомат анализатор, гематологийн анализатор тус тус авсан. Сумын орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн. Нийт 20350000 төгрөгний үнэтэй. 2023 онд Гематологийн аппарат Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан. Лабораторын хөрөгчийг 1100000 ирсэн урвалж оношлуур хадгалалт нь зөв хадгалсан байна. 2024 оны хагас жилийн байдлаар лабораторийн тоног төхөөрөмж шинэчлээгүй байна. Хавсралт : 6 зураг	90%
2	2.1.2. Эрэгтэйчүүдэд	1. Цэргийн насны 18-25 насны	2021 - 2024	200	0	250	Хагас жилийн байдлаар цэргийн насны 18-25 насны эрчүүдийн үзлэг шинжилгээнд нийт 28 цэрэг хамрагдсанаас мэдрэл сэтгэц	70%

<p>чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, тэдний эрүүл мэнддээ тавих анхаарлыг нэмэгдүүлж, ажиллах боловсон хүчнийг бэлтгэн, төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх орчинг бүрдүүлж, “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>	<p>эрчүүдийг үзлэг шинжилгээнд хамруулж, өвчлөлийг илрүүлж, эрүүлжүүлэх</p>						<p>оноштой -M54-, G42-, G54-3-, G44-3-, I67.8-, M54- нийт 5 цэрэг мэдрэл сэтгэцийн өвчлөлтэй гарсан. Чих хамар хоолой оноштой H63.3-, J34.2-3, H61-2, j32-, H66-2, H66.3-, J34.2- нийт 11 цэрэг чих хамар хоолойн өвчлөлтэй гарсан. Мэс засал, гэмтэл оноштой- T92-2, S83, T93-3, k61, I86. нийт 7 цэрэг мэс засал, гэмтэлийн өвчлөлтэй гарсан. Арьс харшил оноштой- L81-1, B35, L82, A51, L70 нийт 5 цэрэг арьс харшилын өвчлөлтэй гарсан. Нүд оноштой- H52-2, H53-2 нийт 4 цэрэг нүд өвчлөлтэй гарсан. Шүд оноштой- K02-11, K08-5, K04-2, K05, K06, K08.2 нийт 21 цэрэг шүдний өвчлөлтэй гарсан.</p>	
<p>3 2.1.3. “Хавдрын эсрэг”, “Элэг бүтэн Монгол”, “Харшлаас сэргийлэх”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.</p>	<p>2. Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>2021 - 2024</p>	<p>4.8</p>	<p>0</p>	<p>3</p>	<p>Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг хийгдээгүй байна. Сургалтын чиглэлээр Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийг энэ жилийн хувьд “Тиймээ Бид Сүрьеэг устгаж чадна” уриан дор тэмдэглэн өнгөрүүлсэн. Сүрьеэгийн халдвараас өөрийгөө урьдчилан сэргийлэх талаар сургалтыг 42 хүнд зохион байгуулсан. Элэгний В, С-гийн шинжилгээ 88 хүнээс авсан. Хариу нь өөрчлөлттэй гарсан хүн байхгүй. “Тиймээ Бид Сүрьеэг устгаж чадна” уриан дор 6-9 дүгээр ангийн сурагчдын дунд “АХА” тэмцээн зохион байгуулсан. Тус тэмцээнд 8б ангийн сурагч Г.Эмүжин 1-р байр, 8а ангийн сурагч Ө.Энхмэнд 2-р байр, 8б ангийн сурагч Б.Бат-Эрдэнэ 3-р байр тус тус эзэлж өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнасан. Сүрьеэгийн халдвараас өөрийгөө урьдчилан сэргийлэх сэдэвт сургалтанд</p>	<p>50%</p>	

							нийт 46 сурагч хамрагдсан. Сургалтын өмнөх мэдлэг 55 хувь байсан бол сургалтын дараа 90 хувьд хүрсэн мэдлэгийн түвшин 35-иар нэмэгдсэн. Сумын эрүүл мэндийн цахим хуудсанд 3-н зурагт хуудас 1 видео байршуулж хандалтын тоо давхардсан тоогоор 563 байсан. Хавсралт : 1 файл	
4	2.2.2. “Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх	1. “Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх	2022 - 2024	0	0	100	2024 оны 03 сарын 06-ны өдөр төрийн албан хаагч нарт зохион байгуулсан. Нийт 42 хүн хамрагдсан. 2024 оны 03 сарын 15-ны өдөр “Дасгал хөдөлгөөн эрүүл мэнд”, “Халдварт бус өвчнөөс сэргийлэх” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Нийт 36-н хүн хамрагдсан. “Дасгал хөдөлгөөн эрүүл мэнд” сэдэвт сургалтыг 04 дүгээр сарын 25-нд зохион байгуулсан. Нийт 68 хүн хамрагдсан. Энэ жилдээ эрүүл жиндээ 2 аяны хүрээнд “Монголжингоо бүсгүйчүүд” өдөрлөгийг 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан. “Зохистой хооллолт”, “Дасгал хөдөлгөөн эрүүл мэнд сэдэвт сургалтыг явуулсан.	70%
5	амьдрал” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2. Спорт заалуудын ашиглалтыг сайжруулах	2021 - 2024	20000	0	30000	2024 оны хагас жилийн байдлаар Нийтийн биеийн тамирын чиглэлээр нийт 23 тэмцээн уралдаан спортын үйл ажиллагаа зохиогдож үүнд Софт волейбол, волейбол, үндэсний бөх, шатар зэрэг төрлөөр явагдсан. Нийт давхардсан тоогоор 650 гаруй иргэд хамрагдсан байна. үүнд хөгжлийн бэрхшээлтэй 4 иргэн дасгал хөдөлгөөн тогтмол хийж байна.	87%
6		3. Заал, талбайн засвар үйлчилгээ хийж, шинээр ашиглалтад оруулах	2021 - 2024	20000	1 сая	10000	2024 оны өсвөрийн волейболын аймгийн аваргийн бэлтгэл ажилийн хүрээнд сургуулийн спорт зааланд засвар хийсэн	50%
7	2.3.2. Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах	1. Тусгай хэрэгцээт боловсролын багш нарыг чадваржуулах	2021 - 2024	96		40	Тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр 5а ангийн М.Аюуш, 9а ангийн сурагч Э.Жамбалбавуу, 3а ангийн сурагч Э.Энхсүлд, 2а ангийн сурагч Н.Номин, 3в ангийн сурагч Э.Жавхаасүрэн, 4а ангийн сурагч Ц.Нандин-Эрдэнэ, 3б ангийн сурагч	100%

	боломжийг бүрдүүлнэ.	сургалтад хамруулах					Н.Жавхаасүрэн нартай Ч.Саруулзаяа, З.Мөнхтунгалаг, Д.Зундуйжамц, У.Чимэгсайхан, Д.Дулмаа, С.Солонго багш нар ганцаарчилсан төлөвлөгөө гарган ажиллаж байна. Хавсралт : 2 зураг	
8	2.3.3. Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын орчныг хүүхэд бүрт ээлтэй болгож, багш нарын ур чадварыг нэмэгдүүлнэ.	3. 5 настай хүүхэд бүрийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулах	2021 - 2024	97	500.000 төгрөг зарцуулсан.	100	2023-2024 оны хичээлийн жилд нийт 5 настай 58 хүүхэд байгаагаас өөр аймаг буюу УБ хотод 8, Баянхонгор аймагт 10 хүүхэд СӨБ-д хамрагдаж байна. 1 хүүхэд ЕБС-д суралцаж байна. Үндсэн бүлэгт 39 хүүхэд буюу 100% СӨБ-д хамруулж сургуульд бэлтгэсэн байдлын үнэлгээ 88%-д хүрсэн. “Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан 19 ажлыг төлөвлөн 9 ажлыг хэрэгжүүлсэн. Aplus.ийн сургалтанд 6 багш 12 сэдвийн хүрээнд хамрагдаж гэрчилгээгээ авсан. Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтанд эрхлэгч, дотоодын сургалтанд 5 сэдвийн хүрээнд давхардсан тоогоор 30 багш хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлсэн. 3 багш гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан ур чадварын нэмэгдэл авч байна. Багш нарын ур чадварын уралдааныг 1 удаа зохион байгуулж, 6 багш хамрагдаж, заах арга ур чадвараа дээшлүүлсэн. Нийт 4 бүлгийн 8 сургалтын төвд 500 гаруй дасгал даалгавар, хэрэглэгдэхүүний баяжилтийг хийсэн. Гадаа талбайд 5ш мод, 8ХЗм.кв туршилтын талбайд манжин, төмс, сонгино тарьсан. Байгууллагын хүлэмжинд өргөст хэмх, улаан лооль, буйцаа, салатны навч зэрэг нарийн ногоог тарьсан. Гадаад дотоод орчны эдгээр ажлуудыг хийж гүйцэтгэхэд 500 мянган төгрөг зарцуулсан.	100%
9	2.3.6. Насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн	1. Тэгш хамран сургах дүйцсэн хөтөлбөр, бичиг үсгийн сургалтын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх	2021 - 2024	250	0	750	Дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд 12 суралцагч хамрагддаг. 7 суралцагч танхимаар 5 суралцагч зайнаас суралцаж байна. Хавар, намрын үндсэн 8 сургалтанд суралцагчдыг хамруулж анги дэвших, сургууль төгсөх шатны мэдлэг ахиулах сургалтыг 80%-ийн чанартай явууллаа.	70%

10	тасралтгүй боловсролыг дээшлүүлнэ.	2. Насанд хүрэгчдийн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх	2021 - 2024	5000 0		15000 3	Насан хүрэгчдийн боловсролыг 12 чиглэлээр тасралтгүй явуулж давхардсан тоогоор 600 ард иргэд сургалтанд хамрагдаж мэдлэг боловсролоо ахиулсан. Хавсралт : 4 зураг	50%
11	2.6.1. Түүх соёлын дурсгал, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлэн сурталчилна.	1. Түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалтыг сайжруулах	2021 - 2024	10		6	Сумын 17 ТСҮХДГазрыг ойролцоо нутагладаг малчдад хариуцуулж гэрээг 2024оны 01сарын 08 өдрөөс шинэчлэн байгуулан ажиллаж байна.СББӨ өвлөн уламжлагч 1хүнийг бүртгэн баримтжуулсан Үүнд монгол уламжлалт гар урлалаар Д.Энхээг бүртгэн авч бүртгэл мэлээллийн санг бий болгосон Миний нутаг сайхан аялалын хөтөлбөрт арга хэмжээ хүлээгдэж байна	70%
12	2.8.7. Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, өрх бүр угийн бичиг хөтөлж, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлсэн байна.	1. Угийн бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх	2021 - 2024	3.2	300 000 төгрөг	70	Гурванбулаг сум үүсгэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот болон Баянхонгор аймгийн төвд оршин сууж буй нутгийн уугуул суугуул иргэдтэй уулзалт, өдөрлөг зохион байгуулав. Үүний үр дүнд сумын 2 ургийн "Угийн бичиг" хөтөлж буй иргэд ах дүү, хамаатан садан, ураг удмынхантайгаа уулзаж, бүртгэл судалгааны ажлыг хийлээ.	50%
3. ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО								
13	3.1.4. Тунгалаг санхүү хөтөлбөрийг	2. Аж ахуйн нэгжүүд, төрийн бус байгууллагууд санхүүгийн	2021 - 2024	80	0	85	2023 оны санхүүгийн тайланг сумд бүртгэлтэй 34 аж ахуй нэгжээс 6 аж ахуй нэгж тайлангаа гаргаагүй байна. Нэг аж ахуй нэгж дарга нас барсан Улсын бүртгэлд жилийн дараа	90%

	хэрэгжүүлнэ.	тайлагналт, баталгаажуулалтын хувийг нэмэгдүүлэх					компаны захирал солигдох шалтгаантай гаргаагүй.	
14		3. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд ашиглаж болох энгийн ойлгомжтой санхүүгийн тайлангийн программыг нэвтрүүлэх	2021 - 2024	40		60	Сумд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүд санхүүгийн тайлангийн програм нэвтрүүлээгүй. Гараар бүртгэлийг хөтлөн ажилладаг. Сангийн яамны https://ebalance.mof.gov.mn/ програмд тайлангаа гарган шивж ажиллаж байна.	70%
15	3.3.2. "Хариуцлагатай уул уурхай- Эдийн засгийн үндэс" сургалтыг уул уурхай бүхий сумдын иргэдэд зохион байгуулна.	1. Уул уурхай бүхий сумдын иргэдэд сургалт зохион байгуулах	2021 - 2024	0		11	Уул уурхайтай холбоотой иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, байгаль орчны нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний оролцооны ач холбогдлын талаарх сургалт мэдээллийг 3 багийн иргэдэд хүргэж сумд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагууд Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээд эхэлсэн байна. Сургалтын мэдээллийг хамтран боловсруулж байна	30%
16	3.3.4. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг бичил уурхай эрхлэгчдийг дэмжиж	1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч нөхөрлөл, хоршоо болон иргэдэд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх чиглэлээр	2021 - 2024	53		25	Гурванбулаг сумын хэмжээнд бичил уурхай эрхлэгч аж ахуй нэгж байхгүй байна.	100%

	ажиллана.	нөлөөллийн ажил зохион байгуулах.						
17	3.3.5. Эвдэрсэн газрын тооллого судалгаан дээр үндэслэн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.	1. Аймгийн хэмжээний эвдэрсэн газрын тооллого, судалгаанд үндэслэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах	2021 - 2024	0		20	Гурванбулаг сумын Давааны ам 2р багийн Ихрийн зүүн салааны шороон ордын эвдэрсэн газарт Жи энд Юу голд ХХК дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийг 10 га талбайд хийж нөхөн сэргээлт хүлээн авах аймгийн комисст танилцуулсан	80%
18	3.6.1. Мал сүргийн шилэн сонголтын ажлыг сайжруулж, малын ашиг шимийн түвшинг нэмэгдүүлж, малчдын мэдлэгийг дээшлүүлнэ.	1. Малын шилэн сонголтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулж орон нутгийн онцлогт тохирсон үүлдэр, омгийн малыг сайжруулагчаар ашиглан ашиг шимийг нэмэгдүүлэх	2021 - 2024	40	0	80	Өөрийн орон нутгийн цөм сүрэг бүхий өрхүүдийн малаас шилэн сонголт хийж бог малын дутагдалтай хээлтүүлэгчийг нөхөхөөр төлөвлөөд байна. Баталгаажсан үүлдэр омгийн малыг сайжруулагчаар ашиглан ашиг шимийн чшглэлээр бүсчилэн үржүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна. Байгалийн шалгарыг даван туулж нутгийн онцлогт дасан зохицсон өөрийн нутгийн малыг өсгөхийг илүүтэй анхаарч байна.	50%
19		3. Малчдын мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлж, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах	2022 - 2024	0	2.250.000 төгрөг	100	Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын нэгдсэн групп-“ээр дамжуулан иргэдэд “Хонь ямааны цэцэг” өвчин “Бог малын мялзан”, “Адууны ям” өвчин малыг хэрхэн тэжээлд оруулах тамир тэнхээг сайжруулах вэ зэрэг цаг үеийн мэдээлэлийг Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын группд байршуулсан. Хөдөөгийн 4-н багаар тойрч малчдад “Хонь ямааны цэцэг” өвчний мэдээллийг хүргэж, гарын авлага 220 ширхэгийг малчдад тарааж 2.250.000 төгрөгийг зарцуулсан.	70%

							Хавсралт : 6 зураг	
20	3.6.2. Мал эмнэлгийн чанар хүртээмжийг сайжруулж, эрүүл бүс статусаа бататгана.	1. Малын халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, угаалга туулгалтад мал сүргийг хамруулах	2021 - 2024	3	малчид болон улс орон нутгийн төсөв	2	Мал амьтны шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит 19 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн 2024 оны 02 дугаар сарын 16–ны өдрийн 181/02 тогтоолоор батлуулсан. Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ угаалгад 35300, туулгад 44600 боловсруулалт 25000, нийт 104900 мал хамруулахаар төлөвлөж төлөвлөгөөг МЭНС-д 100 хувь оруулсан. Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин Шөвөг ярын вакцин 1000 тун, колибактериоз вакцин 32 литр, тугалын иж балнадын вакцин 6 литр, цусан халдвартын вакцин 56 литрийг аймгийн мал эмнэлгийн газраас татан авч аж ахуйн эмч нарт хүлээгэн өгсөн. Сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/27 Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай захирамжаар халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг эхлүүлсэн. Хавсралт нийт : 4 Файл : 1 Зураг : 3	50%
21		2. Мал эмнэлгийн бүртгэл мэдээллийн системийн ашиглалтыг сайжруулж, мал болон малын гаралтай бүтээгдэхүүнд хяналт тавих	2021 - 2024	0	малчдын хөрөнгө	8000	МЭНС-ийн цахим гэрчилгээ бичилт, гүйцэтгэлд аж ахуй нэгжийн эмч нарт арга зүйн зөвлөгөө мэдээлэл өгч шаардлага тавьж, баталгаажуулалтийг хийж хяналт тавин ажиллаж байна. 7 адуу, 20 хонь, 10 ямаа, мал, амьтны мал эмнэлгийн гэрчилгээ үхрийн мах 970 кг, хонины мах 10893 кг, ямааны мах 7220 кг, маханд бүтээгдэхүүний мал эмнэлгийн гэрчилгээ, мөн ямааны арьс 988 ш, ямааны ноолуур 500 кг, хонины арьс 20 ш, хонины өлөн 50 ш, Дэл сүүл 10 кг тус тус мал эмнэлгийн тасаг, малын эмч нартай хамтран амьд мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний цахим гэрчилгээ олгон, баталгаажуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаа Хавсралт : 8 зураг	70%

22		3. Гамшгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор шаардлагатай эм, бэлдмэл, хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх	2021 - 2024	0	3.085.000 төгрөг	20	Мал эмнэлгийн шуурхай бэлэн байдлын үед ажиллах нөөцийг бүрдүүлж нэг удаагийн хувцас 70 ширхэг, нэг удаагийн эмнэлгийн бээлий 2 хайрцаг, маск 200 ширхэг, ажлын бээлий 100 ширхэг, хлорын шохой 250 кг нөөцөлсөн. Хавсралт : 7 зураг	90%
4. ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО								
23	4.3.5. Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд бүх нийтийн хандлагыг төлөвшүүлнэ.	1. Авлигын гэмт хэргийн гаралтын тоог бууруулж, шударга байдлын төвшинг нэмэгдүүлэн, цахим хуудасны ил тод байдлын төвшинг ахиулах	2021 - 2024	5 70 45.8	0	1 0 49	"Авлигын эсрэг соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө"-г үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Сумын вэб хуудасны хөгжүүлэлтийг хуулийн дагуу хийж 80 хувьд хүрсэн. Аймгийн хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэнтэй хамтран Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдэвт сургалтын 103 төрийн албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан. Авлигын эсрэг Гэрэл түгээе аянд сумын Засаг даргын Тамгын газар, төрийн албан хаагчид нэгдсэн. Хавсралт : 5 зураг	90%
24	4.5.1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлж, иргэдэд эрх зүйн харилцаанд оролцох	1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлж, иргэдийн эрх зүйн харилцаанд оролцох чадварыг нэмэгдүүлэх	2021 - 2024	1000	150000	1800	Хууль эрх зүйн мэргэжилтэн "Эрх зүйн хөтөч" бэлтгэх хөтөлбөрт суралцаж 16 кредит цагийг дүүргэсэн. Цахим хурлын тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангаж аймгийн Засаг даргын Тамгын газар болон бусад газруудаас 20 гаруй удаа цахим сургалт мэдээлэл зохион байгуулагдаж давхардсан тоогоор 150 гаруй төрийн албан хаагч, иргэд хамрагдсан. Мэдээллийн цаг арга хэмжээг 14 хоног бүр төрийн байгууллагууд салбарынхаа хууль, тогтоомж, дүрэм журам, цаг үеийн мэдээллийг иргэдэд хүргэж ажиллалаа. Хагас жилийн байдлаар 21 удаагийн танхимын сургалт зохион байгуулж 530 төрийн албан хаагч, иргэд, хүүхэд хамрагдсан. 9 жилийн дунд сургуулийн 9 дүгээр ангийн сурагчдын дунд Алтан хонх	90%

	чадварыг нэмэгдүүлнэ.						тэмцээн зохион байгуулж, эхний 3 байрыг шалгарууллаа. Хууль тогтоомжийн сурталчлах зорилгоор 3 постор бэлтгэн сурталчлан таниулах ажлыг зохион байгууллаа. Хавсралт : 12 зураг	
25	4.6.1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэн, мэргэжилтэй боловсон хүчнээр хангаж, архивын баримтын хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг сайжруулна.	3 . Төрийн болон байгууллагын архивын баримтын цахим санд шилжилтийг эрчимжүүлэх.	2021 - 2024	77,4	Баримтын кардон хавтас, хайрцаг, утас, цаасанд 375,750 төгрөг зарцуулсан	89	Тус байгууллагын 2021 оны байнга хадгалах 1978 (Нэг мянга есөн зуун далан найм) хуудас бүхий 141 баримтыг 4 хувь дансны хамт нэгдүгээр үдэлтийг цагаан цаасан, хоёрдугаар үдэлтийг бор кардоноор үдэж хамгаалалтын хайрцагт хийн цахим санд агуулга, газар зүйн нэр, хүний нэр, байгууллагын нэр гэсэн өгөгдөлд шивж jpg өргөтгөлөөс pdf өргөтгөлд хөрвүүлж өгөгдөл болон багцаар төрийн архивын www.e-document.gov.mn системд холбон цахим сангийн хамтаар аймгийн Төрийн архивын дарга, Архив албан хэрэг хөтлөлтийн улсын байцаагч В.Эрдэнэчимэгийн хяналт дор Сан хөмрөг, тоо бүртгэл, иж бүрэн нягтлан шалгалт хариуцсан фондч Б.Оюунтуяа, Программ хангамж, цахим сүлжээний ажилтан Б.Баттулга, Ахлагч архивч-операторч М.Цэвэлмаа нараар шалгуулан, Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар хэлэлцүүлэн Төрийн архивын 14 дүгээр хөмрөгт бүрдүүлэлт хийн хүлээлгэн өглөө. Хавсралт нийт : 6 Файл : 3 Зураг : 3	100%
26		4. Төрийн болон байгууллагын архивын баримтыг сэлбэн засах.	2021 - 2024	0		1,29	Байгууллагын баримтын тооллогыг хийж тооллогоор илэрсэн 70 жилийн баримтыг эх түр хадгалах баримтаас салган засварлаж үдэж хавтаслан. 70 жилийн бүртгэлд бүртгэж авлаа	90%
5. ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО								
27	5.1.1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг	2. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 20 сая мод	2021 - 2024	24268,88	1.600.000	50000,50	Гурванбулаг сум нь хөрсний үргэлжилсэн мөнх цэвдэгтэй бүс нутаг тул орон нутгийн уур амьсгалд тохирсон мод суулгац төдийлөн дасан зохицохгүй байна. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд байгууллага аж ахуйн нэгж тус бүр	70%

	хэрэгжүүлнэ.	тарих					орчиндоо зүлэг тарих ажилд идэвхитэй хамруулан ажиллалаа. Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Цагдаагийн кабон, Спорт заалны гадна талбайд 30 кг зүлэгний үр тариад байна. Хавсралт : 2 зураг	
28	5.2.1. Булгийн эхийг хамгаалах, ундаргыг сэргээх, хөв байгуулах	1. Булгийн эхийг хамгаалж, ундаргыг сэргээх, хөв байгуулах	2021 - 2024	6		3	манай сумын нутаг дэвсгэрт хамгаалах шаардлагатай булаг шанд байхгүй байна.	100%
29	сэргээх, хөв байгуулах ажлыг зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.	2. Малчид, нөхөрлөлүүдтэй хамтран байгаль орчноо хамгаалах нөлөөллийн олон талт ажлыг зохион байгуулах	2021 - 2024	400		200	Малчид ард иргэд нөхөрлөл байгуулах, Байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах талаар Багийн иргэдийн нийтийн хурал дээр танилцуулан ажилласан. Булаг шанд, рашаан, гол мөрний дагуу хог хаягдлын цэвэрлэгээг тогтмол хийж хэвшсэн. Байгаль орчин аялал жуулчлалын газраас баг тус бүрт 5 идэвхитэн байгаль хамгаалагчийн томилон ажиллуулж байна. Хавсралт : 6 зураг	70%
30	5.2.2. Зэрлэг амьтдыг хамгаалах өвс тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх, амьдрах орчныг сайжруулна.	1. Зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах	2021 - 2024	2	5.000.000	3	Гурванбулаг уул, Хөх нуур, Мөрөн гэсэн газруудад нутгалдаг янгирын сүрэг, бугын сүрэгт Био техникийн арга хэмжээнд нийт 5 тн хужир, 200 боодол өвс тэжээлийг тавиж өгөөд байна. Био техникийн арга хэмжээ авсан тайлан мэдээ бүрийг тухай бүр холбогдох дээд шатны байгууллагад мэдээлж ажилласан. Хавсралт : 6 зураг	100%
31	5.2.3. Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангана.	1. Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2021 - 2024	40		90	Сумын төвийн иргэдийн ундны усны эх үүсвэрээс усны шинжилгээг Стандарт хэмжил зүйн хэлтэс, Геологийн төв лаборатори зэрэг газруудад улирал бүр дээжийг хүргүүлэн шинжлүүлж байна. Мөн дотуур байр, үдийн цай, цэцэрлэгийн ундны усны шинжилгээг тогтмол хийлгэж хэвшсэн. Сумын төвийн иргэдийн усан хангамжийн 2 усан санг улирал бүр эрүүл мэндийн төвөөс ариутгал халдваргүйтлийг хийж байна.	70%

